



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 198

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан (Боловсрол, шинжлэх ухааны сайдын багц) нийт 6,996,641,470.00 (зургаан тэрбум есөн зуун ерэн зургаан сая зургаан зуун дөчин нэгэн мянга дөрвөн зуун дал) төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг хавсралтад заасны дагуу Хөдөө аж ахуйн их сургуульд эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Хөдөө аж ахуйн их сургуулийн ректор Б.Баасансүх нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх, бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА




Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001352  
11-r\_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2024 оны 01 дугаар сарын 28 ны өдрийн  
193 дугаар тогтоолын хавсралт

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН  
ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ**



Д/д	Хөрөнгийн нэр	Хөрөнгийн нийт үнэ (төгрөг)	Барилга байгууламж ашиглалтад оруулсан улсын комиссын актын дугаар
1	Хөдөө аж ахуйн их сургуулийн хичээлийн II байр	6,996,641,470.00	2022.12.21 БА-285/2022
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>6,996,641,470.00 (зургаан тэрбум есөн зуун ерэн зургаан сая зургаан зуун дөчин нэгэн мянга дөрвөн зуун дал)</b>	